



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/197

Хужирт сум

Төв суурингийн 2023-2024 оны
өвөлжилтийн бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай” А/499 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ